

Огноо 2016.02.17

№ 5/001

Улаанбаатар хот

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**“Ачит Алхабы” ХК-ийн удирдлагад**

Бид “Ачит Алхабы” ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тайлбар тодруулагуудыг шалгалаа.

Санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, нөхцөл байдалдаа тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоололыг хийх, санхүүгийн тайлангуудыг аливаа заль мэх эсвэл алдаанаас шалтгаалсан материаллаг буруу илэрхийлэгүйгээр бэлтгэх, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг багтана.

Хийсэн шалгалтаандaa үндэслэн хараат бус аудиторын тайлан бэлтгэх нь бидний үүрэг хариуцлага юм.


Бид ажилдаа Нягтлах Ажлын Олон Улсын Стандарт (2400)-ыг баримтласан. Энэхүү стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан эсэх талаар дунд түвшний баталгаа өгөхийн тулд шалгалтын ажлыг төлөвлөж гүйцэтгэхийг шаарддаг. Нягтлах ажил нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, хөрөнгийн дэлгэрэнгүй үлдэгдэл, авлага, өр төлбөрийн тооцоо нийлсэн акт, хөрөнгийн тооллогын актыг аудитад хамааруулаагүй ба санхүүгийн тайлангуудын уялдааг шинжлэх, удирдлагаас асуулга авах, удирдлагаас хийсэн томоохон тооцоололыг дахин тооцоолох, татварын тайлангуудын дүнг тулгах зэрэг горимуудаар хязгаарлагдсан.

Нягтлах ажлын үр дүнгээр, “Ачит Алхабы” ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, түүнд нийцуулэн гаргасан Аж Ахуйн Нэгж Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу илэрхийлэгдээгүй байна төх зүйл нотоонгоо бидний анхааралд өртөөгүй болно.

Захирал



Д.Эхбаяр



Монгол Улс, Улаанбаатар хот  
СБД, 8-р хороо, Оюутны гудамж-44  
14/2и байр 9 тоот

Утас: 976 (11) 7000 6948

9911 6948

Факс: 976 (11) 7000 6948

И-мэйл: ekhbayar@sgmd-audit.mn

info@sgmd-audit.mn

**АЧИТ АЛХАБЫ ХК**

2016 оны 02 сарын 17

**Санхүүгийн тайлангуудын хураангуй****Санхүүгийн байдлын тайлан**

**Аудитлагдсан дүн**  
**2015.12.31**  
 (мян.төг)

Мөнгөн хөрөнгө	50,896.7
Татвар, НДШ-ийн авлага	97.9
Бараа материал	3,760.0
Үндсэн хөрөнгө	26,871.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>81,626.5</b>
Дансны өглөг	5,792.1
Татварын өр	583.9
Ногдол ашгийн өглөг	83.0
Эздийн өмч	39,241.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,340.1
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	27,585.7
<b>Нийт эх үүсвэр</b>	<b>81,626.5</b>

**Орлогын дэлгэрэнгүй тайлан**

Борлуулалтын орлого	40,522.7
Борлуулалтын өртөг	(33,312.3)
Нийт ашиг	<b>7,210.4</b>
Хүүний орлого	8.9
Борлуулалт, маркетингийн зардал	(5,265.6)
Ерөнхий ба удирдлагын зардал	(1,728.1)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>225.6</b>
Орлогын татварын зардал	22.6
<b>Татварын дараах ашиг</b>	<b>203.0</b>
<b>Цэвэр ашиг</b>	<b>203.0</b>

**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	29,606.5
Нэмэгдсэн өөрчлөлт	203.0
Хасагдсан өөрчлөлт	(2,223.8)
<b>2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>27,585.7</b>

**Мөнгөн гүйлгээний тайлан**

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	16,657.7
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8.9
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,150.6)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>14,516.0</b>

